7-р цэцэрлэг	-	3.1	3.1	0.0
9-р цэцэрлэг	378.9	-	(378.9)	-
14-р цэцэрлэг	12.6	4,464.7	4,452.1	1.1
16 цэцэрлэг	449.7	-	(449.7)	-
НИЙТ ДҮН	622,830.3	403,743.0	(219,087.3)	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2,074,869.8 мянга, эцсийн үлдэгдэл 2,891,599.3 мянган төгрөг болж, 816,729.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	530,406.9	649,789.7	119,382.8	22.5
Эм боох материал	70,807.1	152,664.2	81,857.1	5.3
Бичиг хэргийн материал	72,459.7	81,282.0	8,822.3	2.8
Аж ахуйн материал	323,541.6	517,886.4	194,344.9	17.9
Сэлбэг хэрэгсэл	10,525.4	11,502.5	977.1	0.4
Түлш, шатах тослох материал	4,493.0	4,314.0	-179.0	0.1
Барилгын засварын материал	84,163.6	75,848.0	-8,315.6	2.6
Хүнсний материал	13,227.9	34,817.2	21,589.3	1.2
Бусад хангамжийн материал	832,922.3	1,004,380.4	171,458.1	34.7
Мал амьтад	5,474.0	5,474.0	0.0	0.2
Нөөцийн бараа	126,848.3	353,640.8	226,792.5	12.2
Дүн	2,074,869.8	2,891,599.3	816,729.5	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 816,729.5 мянган төгрөг буюу 39.4 хувиар өссөн нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал, бусад хангамжийн дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн мөн аж ахуйн материал дансны үлдэгдэл 194,344.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн 226,792.5 мянган төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэлийг нөөцийн бараанд бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	14,191.0	10,491.4	(3,699.6)	0.36
ЗДТГ	111,654.0	130,243.7	18,589.7	4.50
Шаргалжуут ТЗА	1,950.0	10,567.0	8,617.0	0.37
ЭМТ	37,347.2	57,520.9	20,173.8	1.99
ОНХС	33,968.3	260,760.8	226,792.5	9.02
Номун далай сургууль	185,433.6	239,644.5	54,210.9	8.29
Номгон сургууль	197,970.8	246,994.8	49,024.0	8.54
Эрдэнмандал сургууль	259,860.7	315,189.7	55,329.0	10.90
Эрдэм сургууль	174,383.2	180,574.9	6,191.7	6.24
Шаргалжуут сургууль	52,002.3	58,838.8	6,836.5	2.03
Баян-Ойт сургууль	75,012.4	91,008.9	15,996.5	3.15
Япон сургууль	46,991.4	59,034.3	12,042.9	2.04
Гэгээн сумди сургууль	-	12,426.8	12,426.8	0.43
1-р цэцэрлэг	88,474.2	115,319.0	26,844.8	3.99
2-р цэцэрлэг	45,314.1	60,441.0	15,126.9	2.09
3-р цэцэрлэг	47,207.9	63,665.5	16,457.7	2.20
4-р цэцэрлэг	52,863.9	61,443.2	8,579.4	2.12
5-р цэцэрлэг	46,895.0	84,887.8	37,992.8	2.94
6-р цэцэрлэг	82,760.6	124,161.3	41,400.7	4.29
7-р цэцэрлэг	40,964.2	58,278.3	17,314.1	2.02
9-р цэцэрлэг	36,346.0	54,435.6	18,089.6	1.88
10-р цэцэрлэг	53,390.8	66,989.7	13,598.9	2.32
11-р цэцэрлэг	42,737.7	60,911.7	18,174.0	2.11
12-р цэцэрлэг	72,109.0	107,957.7	35,848.8	3.73
Шаргалжуут цэцэрлэг	43,048.4	57,238.2	14,189.8	1.98
13-р цэцэрлэг	66,332.0	53,942.8	(12,389.2)	1.87
14-р цэцэрлэг	23,880.7	33,811.7	9,931.1	1.17
15-р цэцэрлэг	40,272.7	89,882.9	49,610.2	3.11
16 цэцэрлэг	101,507.7	124,936.2	23,428.5	4.32
НИЙТ ДҮН	2,074,869.8	2,891,599.3	816,729.5	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 2,518,476.6 мянган төгрөгийн бараа материалын 2,229,277.4 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 54,926.5 мянган төгрөгийн бараа материал хандиваар хүлээн авсан, 209,175.4 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан, 25,097.3 мянган төгрөгийн материал дотоод шилжүүлэг болоод бусад хэлбэрээр авсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	2,518,476.6	Хасагдсан	1,701,747.0
Худалдан авсан	2,229,277.4	Худалдсан, зарцуулсан	1,570,822.9
Хандиваар	54,926.5	Шилжүүлсэн	75,026.0
Шилжүүлэн авсан	209,175.4	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	1,805.2
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	5,982.6	Бусад	54,092.9
Бусад	19,114.7		1,701,747.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 39,351,560.5 мянга, эцсийн үлдэгдэл 48,504,620.6 мянган төгрөг болж, 9,153,060.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	35,101,082.1	44,158,047.2	9,056,965.1	91.0
Барилга байгууламж, орон сууц	29,457,101.2	37,765,504.9	8,308,403.6	77.9
Тээврийн хэрэгсэл	255,061.6	238,871.6	(16,190.0)	0.5
Машин тоног төхөөрөмж	2,893,223.5	3,386,422.8	493,199.4	7.0
Тавилга эд хогшил	1,982,913.9	2,262,506.6	279,592.8	4.7
Түүх соёлын дурсгалт зүйл	194.7	194.7	-	0.0
Номын фонд	221,589.6	246,164.6	24,575.0	0.5
Бусад үндсэн хөрөнгө	290,997.6	258,381.9	(32,615.7)	0.5
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	4,250,478.4	4,346,573.4	96,095.0	9.0
Программ хангамж	30,485.4	48,055.4	17,570.0	0.1
Бусад биет бус хөрөнгө	4,219,993.0	4,298,518.0	78,525.0	8.9
НИЙТ ДҮН	39,351,560.5	48,504,620.6	9,153,060.1	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 9,153,060.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс Номундалай цогцолбор сургууль 8,733,591.8 мянга, 6 дугаар сургуулийн 180,567.0 мянга, 16 дугаар цэцэрлэгийн 142,986.5 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
6-р сургууль	-	180,567.0	180,567.0	0.37
1-р сургууль	3,265,871.2	11,999,463.0	8,733,591.8	24.74
1-р цэцэрлэг	1,419,622.1	1,447,616.0	27,994.0	2.98
10-р цэцэрлэг	2,183,433.7	2,188,519.2	5,085.5	4.51
11-р цэцэрлэг	903,338.0	919,786.5	16,448.5	1.90
12-р цэцэрлэг	568,929.0	596,139.2	27,210.2	1.23
13-р цэцэрлэг	565,654.3	569,181.9	3,527.5	1.17
14-р цэцэрлэг	392,022.3	408,420.8	16,398.5	0.84
15-р цэцэрлэг	857,935.4	876,726.9	18,791.5	1.81
16-р цэцэрлэг	2,092,910.3	2,235,896.8	142,986.5	4.61
2-р сургууль	3,692,310.8	3,397,069.7	(295,241.1)	7.00
2-р цэцэрлэг	587,992.3	606,436.8	18,444.5	1.25
3-р сургууль	4,638,759.6	4,680,335.4	41,575.8	9.65
3-р цэцэрлэг	806,561.9	810,510.9	3,949.0	1.67
4-р сургууль	2,831,690.3	2,887,630.0	55,939.7	5.95
4-р цэцэрлэг	799,724.1	802,299.1	2,575.0	1.65
5-р цэцэрлэг	1,474,053.1	1,477,315.2	3,262.1	3.05
6-р цэцэрлэг	1,611,712.3	1,613,197.8	1,485.5	3.33
7-р цэцэрлэг	712,680.3	711,109.7	(1,570.6)	1.47
8-р цэцэрлэг	1,277,030.2	1,278,008.7	978.4	2.63
9-р цэцэрлэг	602,765.5	620,799.0	18,033.6	1.28
Баян-Ойт сургууль	2,264,237.9	2,287,477.3	23,239.4	4.72
Засаг даргын тамгын газар	1,980,583.2	2,009,779.1	29,195.9	4.14
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	75,310.2	91,723.5	16,413.3	0.19
Шаргалжуут сургууль	678,103.4	662,103.0	(16,000.4)	1.37
Шаргалжуут тосгоны ЗАА	337,050.1	337,050.1	-	0.69
Шаргалжуут эмнэлэг	1,277,692.8	1,312,833.2	35,140.4	2.71
Япон сургууль	1,453,586.3	1,496,625.0	43,038.7	3.09
НИЙТ ДҮН	39,351,560.5	48,504,620.6	9,153,060.1	100

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нэмэгдсэн 9,986,580.0 мянган төгрөгийн хөрөнгө нь 554,479.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 20,892.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, өмнөх оны авлагаар бүртгэсэн 365,945.4 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж, 9,045,263.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	9,986,580.0	Хасагдсан	833,520.0
Худалдан авсан	554,479.0	Худалдсан	-
Хандиваар	20,892.1	Акталсан	255,460.5
Шилжүүлэн авсан	9,045,263.6	Шилжүүлсэн	577,215.6
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	-	Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	843.9
Бусад	365,945.4	Бусад	-

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,737.9 мянга, эцсийн үлдэгдэл 8,132.6 мянган төгрөг болж 4,394.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------------	-----------------

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	3,737.9	8,132.6	4,394.7	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	2,764.1	2,254.6	-509.5	27.7
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	179.7	1,860.9	1,681.2	22.9
Байгууллагад төлөх өглөг	118.8	3,672.8	3,554.0	45.2
Хувь хүмүүст төлөх өглөг	675.3	344.3	-331.0	4.2
Дүн	3,737.9	8,132.6	4,394.7	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2,254.6 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 1,860.9 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын, 4,017.1 мянган төгрөгийн хувь хүнд болон байгууллагад төлөх өглөг байгаа ба Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 4,632.6 мянган төгрөгийн өглөг үүссэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ	456.1	199.7	(256.4)	2.5
Шаргалжуут тосгоны ЗАА	159.1	-	(159.1)	-
ЭМТ	-	4,632.6	4,632.6	57.0
Номун далай сургууль	319.4	1,716.4	1,397.0	21.1
Номгон сургууль	1,596.2	39.9	(1,556.3)	0.5
Эрдэм сургууль	277.0	-	(277.0)	-
Шаргалжуут сургууль	-	-	-	-
Баян-Ойт сургууль	4.4	-	(4.4)	-
1-р цэцэрлэг	22.5	-	(22.5)	-
2-р цэцэрлэг	-	635.6	635.6	7.8
3-р цэцэрлэг	-	132.3	132.3	1.6
5-р цэцэрлэг	20.5	85.2	64.6	1.0
7-р цэцэрлэг	-	284.1	284.1	3.5
10-р цэцэрлэг	101.5	254.4	152.9	3.1
Шаргалжуут цэцэрлэг	-	63.4	63.4	0.8
13-р цэцэрлэг	302.5	-	(302.5)	-
14-р цэцэрлэг	-	89.0	89.0	1.1
15-р цэцэрлэг	478.8	-	(478.8)	-
НИЙТ ДҮН	3,737.9	8,132.6	4,394.7	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 37,445,630.4 мянга, эцсийн үлдэгдэл 46,202,577.7 мянган төгрөг болж, 8,756,947.4 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,217,149.8	14,355,674.8	138,525.0	31.1
Өмч: - төрийн	14,217,149.8	14,355,674.8	138,525.0	31.1
Хуримтлагдсан үр дүн	10,525,620.6	19,145,348.5	8,619,727.9	41.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,702,859.9	12,701,554.4	(1,305.5)	27.5
Дүн	37,445,630.4	46,202,577.7	8,756,947.4	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 46,202,577.7 мянган төгрөг болж 8,756,947.4 1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 8,619,727.9 мянган төгрөгийн өсөлт, 1,305.5 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.5.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.17-ны өдрийн хуралдааны 2/5 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 1,812,868.0 мянга, хүү торгуулийн орлогыг 85,261.6 мянга, нийт 1,898,129.6 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	1,812,868.0	1,948,440.6	166,685.4	107.5
1.1.ИОТХ	391,788.0	164,272.8	(227,515.2)	41.9
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	604,000.0	725,901.8	121,901.8	120.2
1.3. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	193,000.0	307,388.0	114,388.0	159.3
1.4.Бууны татвар	7,000.0	5,527.0	(1,473.0)	79.0
1.5.Улсын тэмдэгийн хураамж	15,000.0	19,360.8	4,360.8	129.1
1.6. Газрын төлбөр	35,080.0	28,994.1	(6,085.9)	82.7
1.7. Ус рашаан ашигласны төлбөр	10,000.0	7,294.7	(2,705.3)	72.9
1.8. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	550,000.0	524,711.2	(25,288.8)	95.4
1.9. ТТАМАТөлбөр	7,000.0	-	(7,000.0)	-
1.10. Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	163,814.4	163,814.4	-
1.11. Бусад орлого	-	1,176.0	1,176.0	-
2.Татварын бус орлого	85,261.6	28,018.3	(57,243.3)	(67.1)
2.1.Хүү торгуулийн орлого	85,261.6	28,018.3	(57,243.3)	32.9
Нийт дүн	1,898,129.6	1,976,458.9	167,861.4	104.1

Сумын төсөвт төвлөрөх нийт орлогыг 167,861.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байгаа ба үүнд үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 114,388.0 мянган төгрөгөөр давж биелэн, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн 163,814.4 мянган төгрөгийн төлөвлөөгүй орлого орсон нь гол нөлөөг үзүүлж байна.

Харин ИОТХ, бууны татвар, газрын төлбөр, ус рашаан ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хүү торгуулийн орлогын төлөвлөгөө тус тус биелээгүй тасарсан байна.

3.5.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 24,022,212.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 22,757,118.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 22,483,118.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 274,000.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 28 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.17-ний өдрийн 2/5 дугаар тогтоолоор нийт 23,563,993.1 мянган төгрөгийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.15-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор анх 23,563,993.1 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.29-ний өдрийн 3/7 дугаар

тогтоолоор 880,296.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 348,880.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 24,137,977.3 мянган төгрөг болжээ.

Харин шинээр ашиглалтад орохоор хүлээгдэж буй 5 дугаар сургуулийн тогтмол зардал 115,764.4 мянган төгрөгийг хасаж тодотгоогүй байгаа ч тус сумын санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдээгүй аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хувийн сургууль гэсэн ангиллаар нэгтгэгдэхээр Засгийн газрын удирдлага мэдээллийн системд бүртгэгдсэн тул тус дүнг хасаж сумын нийт батлагдсан төсвийг 24,022,212.9 мянган төгрөгөөр нэгтгэсэн болно.

Нийт зардлын 17,485,979.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 309,758.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 3,308,991.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 1,898,129.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогоор, 299,696.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 14,247.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 821,173.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 3,026.3 мянган төгрөгөөр дутуу, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 5 дугаар сургуулийн тогтмол зардал 115,764.6 мянган төгрөгөөр дутуу авсан ба улсын төсөвт 287,036.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын тамгын газар	1,936,122.7	1,821,602.8	114,519.9	94.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	302,262.8	301,024.2	1,238.6	99.6
1-р сургууль	4,052,701.4	4,049,742.8	2,958.6	99.9
1-р цэцэрлэг	683,186.5	669,297.9	13,888.6	98.0
2-р сургууль	2,793,168.2	2,717,020.4	76,147.8	97.3
2-р цэцэрлэг	381,261.5	380,113.6	1,147.9	99.7
3-р сургууль	2,227,475.9	2,227,014.4	461.5	100.0
3-р цэцэрлэг	443,347.9	405,120.6	38,227.3	91.4
4-р сургууль	1,772,893.8	1,743,375.1	29,518.7	98.3
4-р цэцэрлэг	358,446.9	344,331.9	14,115.0	96.1
5-р цэцэрлэг	562,316.3	555,344.6	6,971.7	98.8
6-р сургууль	152,771.7	147,397.6	5,374.1	96.5
6-р цэцэрлэг	540,261.1	530,452.1	9,809.0	98.2
7-р цэцэрлэг	452,993.9	432,721.8	20,272.1	95.5
8-р цэцэрлэг	223,380.1	214,368.9	9,011.2	96.0
9-р цэцэрлэг	343,082.5	331,006.1	12,076.4	96.5
10-р цэцэрлэг	545,041.7	519,223.0	25,818.7	95.3
11-р цэцэрлэг	417,150.8	393,638.1	23,512.7	94.4
12-р цэцэрлэг	425,919.6	417,128.2	8,791.4	97.9
13-р цэцэрлэг	345,611.7	340,640.7	4,971.0	98.6
14-р цэцэрлэг	298,143.3	262,373.1	35,770.2	88.0
15-р цэцэрлэг	464,711.4	459,679.1	5,032.3	98.9
16-р цэцэрлэг	682,797.6	666,704.8	16,092.8	97.6
Баян-ойт сургууль	778,346.3	757,637.3	20,709.0	97.3
Сум хөгжүүлэх сан	691,170.0	33,554.0	657,616.0	4.9
Шаргалжуут сургууль	455,620.9	431,570.5	24,050.4	94.7
Шаргалжуут тосгоны ЗАА	44,070.4	42,422.3	1,648.1	96.3
Шаргалжуут эмнэлэг	378,807.9	372,375.2	6,432.7	98.3
Япон сургууль	931,809.2	916,236.8	15,572.4	98.3
Орон нутгийн хөгжлийн сан	337,338.9	274,000.8	63,338.1	81.2
Нийт дүн	24,022,212.9	22,757,118.8	1,265,094.1	94.7

Эх сурвалж: Баянхонгор сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 22,757,118.8 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын зардлыг 114,519.9 мянга, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын урсгал зардлыг 245,508.2 мянга, ерөнхий боловсролын

сургуулиудын урсгал зардлыг 174,792.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн мөн сум хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4 байгууллага 138,489.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 19 байгууллага 1,297,194.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 6 байгууллага 70,364.1 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 79,855.0 мянга нийт 1,585,902.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 810,692.6 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 488,648.6 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 271,492.6 мянга, нийт 1,570,833.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 15,068.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санд 157,000.0 мянга, гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгааны зардалд 213,354.6 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 370,256.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Баянхонгор сумыг 2021 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 137 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83.0 хувийн гүйцэтгэлтэй, Баянхонгор сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 78.0 хувийн биелэлттэй гэж тайлагнажээ.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 28 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 30 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 28 төсвийн байгууллага, 2 тусгай сан нь бүгд аудитад хамрагдсанаас 25 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллага, 2 тусгай сангийн тайланг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан

байгууллагуудаас 5 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч бусад байгууллагуудад зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Хүснэгт 16. Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагууд

БАЙГУУЛЛАГЫН НЭР		ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"		
БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭМ СУРГУУЛЬ	Бараа материалд орлогоор сонины үнэ, хогны төлбөр, санхүүгийн программын лицензийн төлбөр зэрэг шууд зардал бүртгэсэн, төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 3,605.8 мянган төгрөгийн эм боох материалыг акталсан, тайлант онд бэлтгэсэн бараа материалыг нэр төрлөөр нь бүртгээгүй, өмнөх жилийн аудитаар байгууллагын жилийн эцсийн тооллого, тооцоог бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлэх зөвлөмжийг өгсөн байхад зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	
БАЯНХОНГОР СУМЫН 14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, нярав бараа материалын тайланг зохих стандартын дагуу гаргаагүй байхад дарга, нягтлан бодогч нар хяналт тавиагүй, цалингийн зардлын хэмнэлтийг урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан, өмнөх оны аудитаар Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан орон тоонд багтаан ажиллах зөвлөмжийг өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй 2021 онд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан.	
БАЯНХОНГОР СУМЫН 11 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй худалдан авсан хүнсний тайланг нярав тайлан гаргасан байхад Нягтлан бодогч нь санхүүгийн программд бараа материалыг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн байна. Санхүүгийн тайлан, няравын тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	
БАЯНХОНГОР СУМЫН 13 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ	Аймгийн Онцгой комиссоос хоол бэлтгүүлэхээр олгосон 23,364.5 мянган төгрөгийг хүнсний материалын орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй байна. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед байгууллагын төсвөөс нэмж 14,116.3 мянган төгрөгийг нэг удаагийн аяга, таваг халбага уут зэргийг худалдан авч зарцуулахдаа Төсвийн захирагч шийдвэр гаргаагүй.	
БАЯНХОНГОР СУМЫН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ	2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас төлөх төлбөрийн актыг төсвөөс төлсөн. Засгийн газрын 2021 оны 43 дугаар батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар арга хэмжээний тухай" тогтоолыг баримталж ажиллалгүй албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон, хүнсний материал нөөцөлж төсөвт төвлөрүүлээгүй байна.	

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 268,010.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10,798.9 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 7,518.0 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 157,570.9 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 92,122.1 мянган төгрөгийн 12 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
а.Санхүүгийн тайлангийн зөрчил	69	300,321.1	12	126,628.7	20	35,957.9	12	29,434.8	25	108,299.7
7 дугаар цэцэрлэг	6	1,879.5	4	1,325.1					2	554.4
Эрдэм ахлах сургууль	9	125,032.7	1	92,880.0	1	1,131.9	2	7,220.0	5	23,800.8
4 дүгээр цэцэрлэг	2	10,009.3	1	10,009.3					1	-

Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
14 дүгээр цэцэрлэг	7	18,196.3	1	5,859.8	1	4,464.7	2	-	3	7,871.8
6 дугаар цэцэрлэг	3	8,692.6	1	7,620.0					2	1,072.6
Номун далай цогцолбор сургууль	3	6,284.2	2	5,552.2	1	732.0			0	-
10 дугаар цэцэрлэг	2	2,522.6			1	2,522.6			1	-
9 дүгээр цэцэрлэг	5	5,028.4			2	2,248.6	1	1,545.9	2	1,233.9
11 дүгээр цэцэрлэг	3	8,381.7			1	116.9	1	7,755.0	1	509.8
Сум хөгжүүлэх сан	1	11,461.0			1	11,461.0				
Орон нутаг хөгжлийн сан	1	-							1	-
1 дүгээр цэцэрлэг	3	792.2			1	652.4	1	139.8	1	-
5 дугаар цэцэрлэг	1	594.1					1	594.1		
3 дугаар цэцэрлэг	5	3,052.0	1	552.6	3	2,022.0	1	477.4		
15 дугаар Цэцэрлэг	4	3,632.4			3	973.7			1	2,658.7
Номгон Ерөнхий боловсролын сургууль	2	2,309.2			1	777.3	1	1,531.9		
13 дугаар цэцэрлэг	3	43,386.6			1	2,686.6			2	40,700.0
2 дугаар цэцэрлэг	4	8,997.7	1	2,829.6	3	6,168.1				
ЗДТГ	2	30,518.0					1	8,518.0	1	22,000.0
Шаргалжуут Ерөнхий боловсролын сургууль	1	1,513.2							1	1,513.2
Баян-Ойт цогцолбор сургууль	1	6,384.6							1	6,384.6
16-р цэцэрлэг	1	1,652.7					1	1,652.7		
а.СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал	34	527,102.7	0	-	0	-	6	73,470.8	28	453,631.9
Соого Сейкео сургууль	1	15,633.2							1	15,633.2
7 дугаар цэцэрлэг	1	-							1	-
Эрдэм ахлах сургууль	1	52,396.0					1	52,396.0		
4 дүгээр цэцэрлэг	2	11,447.8							2	11,447.8
14 дүгээр цэцэрлэг	2	7,346.2							2	7,346.2
6 дугаар цэцэрлэг	1	-							1	-
ИТХ	1	5,400.0	0	-	0	-	0	-	1	5,400.0
Номун далай цогцолбор сургууль	3	21,819.5							3	21,819.5
10 дугаар цэцэрлэг	1	255.9							1	255.9
9 дүгээр цэцэрлэг	3	10,000.0					2	10,000.0	1	-
11 дүгээр цэцэрлэг	2	661.1					1	-	1	661.1
Эрдэнэмандал ахлах сургууль	1	11,074.8					1	11,074.8		
1 дүгээр цэцэрлэг	2	9,873.0							2	9,873.0
5 дугаар цэцэрлэг	2	-							2	-
3 дугаар цэцэрлэг	1	-					1	-		
15 дугаар Цэцэрлэг	2	116,309.3							2	116,309.3
12 дугаар Цэцэрлэг	1	4,037.1							1	4,037.1
Гэгээн сумад сургууль цэцэрлэгийн цогцолбор	0	-								
Номгон Ерөнхий боловсролын сургууль	1	55,213.3							1	55,213.3
2 дугаар цэцэрлэг	2	35,228.2							2	35,228.2
ЗДТГ	1	13,948.9							1	13,948.9
Шаргалжуут Ерөнхий боловсролын сургууль	1	8,644.1							1	8,644.1
Баян-Ойт цогцолбор сургууль	1	131,620.1							1	131,620.1
16-р цэцэрлэг	1	16,194.2							1	16,194.2
Нийт зөрчлийн дүн	103	827,423.8	12	126,628.7	20	35,957.9	18	102,905.6	53	561,931.6

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 300,321.1 мянган төгрөгийн 69 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 527,102.7 мянган төгрөгийн 34 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 568,976.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг Баянхонгор сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад нийт 24 байгууллагад алдаа, зөрчил илэрч зөрчлийг арилгах 73,470.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага, алдаа, зөрчлийн давтан гаргуулахгүй байх 453,631.9 мянган төгрөгийн 28 зөвлөмжийг төсвийн захирагч нарт хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 115,037.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 64,571.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 50,466.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Баянхонгор сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 53,497.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4,854.6 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж 48,651.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.1 Залруулсан алдаа

1. Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 4405.6 мянган төгрөгийн акталсан бараа материалыг зарцуулснаар, 12 дугаар цэцэрлэгийн цалингийн зардлын төлөвлөгөөг 440.0 мянган төгрөгөөр төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрүүтэй нэгтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 3.1 дэх “Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасны дагуу Засгийн газар, төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн тайлагналын зорилгоор хяналтад байгаа төсөвт байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайланг толилуулна” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав.

4.3 Зөвлөмж

1. Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын болон бус орлогоор 1,976,458.9 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 1,970,940.9 мянган төгрөг буюу 5,518.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид орон нутгийн дансанд төвлөрсөн орлогын тайлан мэдээг Татварын хэлтэст үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

2. Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж байх, мөн хуулийн 64.1.3-т заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх зөвлөмж өгөв.

3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар тус сумд олгох тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг 348,880.0 мянган төгрөгөөр хассан байхад сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос 43,133.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 07 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/											
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Баянхонгор сумын ТТЗ	4	53497.0	1	4845.6					3	48651.4
	Дүн	4	53497.0	1	4845.6					3	48651.4